

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төсөл
Байршил:	Дорноговь аймгийн Иххэт сум
Төсөл хэрэгжүүлэгч:	“Төвшин” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019077095
Регистрийн дугаар:	2028565
Тусгай зөвшөөрөл:	MV-009968, MV-011989
Хаяг:	Монгол улс, Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, бага тойруу, Зоос гоёл ХХК-ны байр 205 тоот
Утас:	+976-9199-9489, +976-9502-6502
Хариуцах хүн:	Ерөнхий инженер С.Баяраа Байгаль орчны мэргэжилтэн Ц.Мэндбаяр Environment0429@gmail.com
БОНБЕҮ, шийдвэрийн төсөл:	“Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам”-ны 2025 оны 6 сарын 26-ны өдрийн 12/3019
БОНБНҮ хийсэн аж ахуй нэгжийн нэр:	“Дорнын байгаль” ХХК
БОНБНҮ батлуулсан огноо:	2026 он

ТОВЧИЛСОН ҮГ

БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
БОНБЕҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОУАӨЯ	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОГ	Байгаль орчны газар
БОХТ	Байгаль орчны хамгаалах тухай хууль
ОХШХ	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
УАХ	Уул ашиглалтын хэсэг
УАТ	Уулын ажлын төлөвлөгөө
БОМ	Байгаль орчны мэргэжилтэн
БО	Байгаль орчин
ҮТХ	Үйлдвэр технологийн хэлтэс
ХММЗХ	Хүнд машин механизмын засварын хэсэг
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
НБХХ	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл
ХАЛМ	Химийн бодисын хор аюулын лавлагаа мэдээлэл
ХАБЭАБО	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин
ХХТХ	Хог хаягдлын тухай хууль
УТХ	Усны тухай хууль
ГТХ	Газрын тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТТАМО	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	7
1.1. Төслийн зорилго	7
1.2. Төслийн байршил	8
1.3. Төсөл хэрэгжүүлэх үндсэн суурь нөхцөл	9
1.4. Ордын нөөц	10
1.5. Ил уурхайн олборлолтын технологи	10
1.7. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын тооцоо	11
1.8. Далд уурхайн технологи	12
1.9. Далд уурхайн ашиглалтын нөөцийн тооцоо	12
1.10. Ашиглалтын системийн сонголт	14
1.11. Далд уурхайн аргаар ашиглах үеийн жонш олборлолтын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	15
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	16
2.1. Байгаль, газар зүйн онцлог	16
2.2. Зам тээвэр	16
2.3. Усан хангамж	16
2.4. Ариутгах татуурга	16
2.5. Дулаан хангамж	17
2.6. Агаарын чанар	17
2.7. Хөрсөн бүрхэвч	17
2.8. Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл	17
2.9. Гадаргын болон газрын доорх ус	17
2.10. Амьтны аймаг	17
2.11. Ургамлан нөмрөг	18
2.12. Нийгэм эдийн засаг	18
2.13. Төслийн хөрөнгө оруулалт	18
2.14. Төслийн борлуулалтын орлого	18
2.15. Татвар төлбөр	19
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	19

3.1.	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	19
3.2.	Төслийн нийт нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа.....	20
3.3.	Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.....	21
3.4.	Газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ.....	21
3.5.	Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ.....	22
2.6.	Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ.....	23
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
5.1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	25
5.2.	Гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	28
5.3.	Хөрсөн бүрхэвч, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	29
5.4.	Ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	30
5.5.	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	31
6.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
7.	"ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	33
8.	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	36
9.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	37
10.	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
11.	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	39
12.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	42
13.	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	45
14.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	47
15.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	48

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. MV-009968 Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол.....	8
Зураг 2. MV-011898 Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол.....	8
Зураг 3. Тусгай зөвшөөрөлтэй талбай	9
Зураг 4. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил	9
Зураг 5. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд мод тарих байршил	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ил уурхайн хүрэн дэх жонш олборлолтын хэмжээ	11
Хүснэгт 2. Хөрсний гадаад овоолгын төлөвлөлт	11
Хүснэгт 3. Далд уурхайн ашиглалтын блокууд, ашиглалтын нөөцийн тооцоо	13
Хүснэгт 4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ	19
Хүснэгт 5. Төслийн нийт нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа	20
Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт	21
Хүснэгт 7. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дүгнэлт	22
Хүснэгт 8. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт	22
Хүснэгт 9. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт	23
Хүснэгт 10. 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл	24
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд баримтлах хуулийн жагсаалт	25
Хүснэгт 12. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	27
Хүснэгт 13. Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	28
Хүснэгт 14. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	29
Хүснэгт 15. Ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	30
Хүснэгт 16. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	31
Хүснэгт 17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	32
Хүснэгт 18. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд мод тарих байршлын координат	33
Хүснэгт 19. "Тэрбум мод" хөтөлбөрийн төлөвлөгөө	33
Хүснэгт 20. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд 2.0 га талбай хашаажуулах төлөвлөгөө	34
Хүснэгт 21. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	36
Хүснэгт 22. Нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний төлөвлөгөө	37
Хүснэгт 23. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	38
Хүснэгт 24. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	40
Хүснэгт 25. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	43
Хүснэгт 26. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	45
Хүснэгт 27. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	47
Хүснэгт 28. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	48

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төвшин ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан, Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших 31,68га бүхий Цагаан элгэн нэртэй талбайн MV-009968 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2007 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Ашигт малтмалын газрын тосны газрын Геологи уул уурхайн кадастрын албаны даргын шийдвэрээр “Эж Эрдэнэ” ХХК-д олгосон байдаг. Тус ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдөр “Төвшин” ХХК-д өөрийн нэр дээр шилжүүлэг авсан юм. Мөн тус Цагаан элгэн нэртэй талбайн MV-011898 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 70.97га талбайг 2007 оны 1 сарын 29-ний өдөр Ашигт малтмал газрын тосны газрын Геологи уул уурхайн кадастрын албаны даргын шийдвэрээр “Эж Эрдэнэ” ХХК-д олгосон байдаг ба 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдөр “Төвшин” ХХК өөрийн нэр дээр шилжүүлэн авсан юм.

Төвшин” ХХК нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дэвсгэрт MV-009968 тусгай зөвшөөрөлтэй 31.68 га, MV-011898 тусгай зөвшөөрөлтэй 70.97 га талбай бүхий “Цагаан элгэн” хайлуур жоншны 1, 2-р хүдрийн биетийг далд уурхайн аргаар ашиглах төслийн БОНБНҮ-ний тайланг 2022 онд “Тeam смaйл” ХХК мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн БОАЖЯ-хянан баталж 2022 оноос олборлолтын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2023, 2024 онуудад уурхайн үйл ажиллагааг явуулаагүй бөгөөд 2025 оны БОМТ-г “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт/ -ын дагуу боловсруулж БОУАӨЯ хянан баталж хэрэгжилтийг 92% гүйцэтгэлтэйгээр хангаж ажилласан юм.

Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаан элгэний хайлуур жоншны ордын 1,2-р хүдрийн биетийг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1 (Тусгай зөвшөөрлийн талбай MV-009968 MV-011898) 2025 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хянан баталж Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2025 оны 6 сарын 2-ны өдрийн Т/89 тоот тушаалаар “Техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол”-ыг бүртгэсэн юм. Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг байрлах “Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн БОНБНҮ-ний тодотгол тайланг БОАЖЯ (хуучин нэрээр) 2025 оны 06-р сарын 26-ны өдрийн 12/3219 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн “Дорнын байгаль” ХХК мэргэжлийн байгууллага боловсруулан БОУАӨЯ хянан баталсан.

1.1. Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч “Төвшин” ХХК нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаан элгэний хайлуур жоншны ордыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль дүрмийн хүрээнд аюул осолгүй, үйлдвэрлэл явуулах замаар үнэ цэнэ, ач холбогдлыг нэмэгдүүлж, ашиглалтын зардлыг боломжит бага байлгаж, Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, экспортын хэмжээг

нэмэгдүүлж, орд газрын үр өгөөжийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

1.2. Төслийн байршил

Цагаан Элгэний хайлуур жоншны орд нь засаг захиргааны хувьд Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 410 км, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс зүүн зүгт 90 км, Иххэт сумаас зүүн тийш 25 км зайтай. Талбай нь номенклатурын хувьд L-49-65 планшетад байрладаг.

Зураг 1. MV-009968 Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол

		Mineral Resources & Petroleum Authority of Mongolia Cadastre Division					
Code:	MV-009968						
Name:	Cagaan elgen						
Type:	Mining License						
Status:	Valid						
Holder:	To'vshin						
Area (ha):	31.68						
Coordinates:							
#	#	Longitude			Latitude		
		Degrees	Minutes	Seconds	Degrees	Minutes	Seconds
1	1	110	24	23.87	46	19	41.66
1	2	110	24	23.87	46	20	1.65
1	3	110	23	59.86	46	20	1.65
1	4	110	23	59.86	46	19	41.66


Зураг 2. MV-011898 Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол

		Mineral Resources & Petroleum Authority of Mongolia Cadastre Division					
Code:	MV-011898						
Name:	Cagaan elgen						
Type:	Mining License						
Status:	Valid						
Holder:	To'vshin						
Area (ha):	70.97						
Coordinates:							
#	#	Longitude			Latitude		
		Degrees	Minutes	Seconds	Degrees	Minutes	Seconds
1	1	110	23	59.86	46	20	17.65
1	2	110	23	47.86	46	20	17.65
1	3	110	23	47.86	46	19	32.65
1	4	110	24	34.87	46	19	32.65
1	5	110	24	34.87	46	20	1.65
1	6	110	24	23.87	46	20	1.65
1	7	110	24	23.87	46	19	41.66
1	8	110	23	59.86	46	19	41.66

Зураг 3. Тусгай зөвшөөрөлтэй талбай



Зураг 4. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил



1.3. Төсөл хэрэгжүүлэх үндсэн суурь нөхцөл

Хүдрийн биетийн зузаан нь газрын гадаргуугийн ойрхон хэсэгтээ 0.5-1.8 м-ийн хооронд хэлбэлзэж, газрын гүндээ 5-8 м хүртэл өргөсөн 68-700 уналтай, 300-350 м-ийн урттай байрлаж байгаа кварц-флюоритийн үндсэн нэг судал юм. Газрын гадаргуугийн ойр 5 м-ийн гүнд жоншны судлын 2 талын хил заагийн орчмын липарит-порфиритийн дотор ойролцоогоор 0.5-0.8 м-ийн зайд кальцит болон карбонат, кварц флюоритийн 0.5-5.0 см-ийн өргөнтэй нарийн судлууд үндсэн судлын хүдрийн биетийн хажуугаар зэрэгцээ байдалтай байрлаж гүндээ хүдрийн биетдээ улам ойртон нэгдэн нийлж

байна. Энэ нь хүдрийн биетийн зузаан өргөсөн тогтворжиж, агуулга жигд өндөрсөж, гүндээ СаF2 агуулга 40.92-97.53 %-ийн хооронд хэлбэлзэж жигд байгаад онцын нөлөө үзүүлэхгүй. Гидротермаль уусмал газрын гадаргууд ойртон ирэх үеэр агуулагч чулуулгийн жижиг ан цав тектоник хагарал, эвдрэлийн бүс даган үүссэн кварц, серицит, цахиуржилт, брекчийн гидротермаль хувирлыг даган кварц-флюорит, кальцит, флюоритийн судлын төрлийн биетүүд үүсгэдэг. Жонш нь ягаан, ногоон, цагаан өнгийн СаF2-ийн агуулга өндөртэй, том ба дунд ширхэглэлийн текстуртэй, агаарт удаан байсан тохиолдолд амархан бутрамтгай байдалтай болно. Хүдрийн биетийг агуулж байгаа липарит-порфирит нь цайвар цагаан, цайвар шаргал өнгөтэй, цул, флюидал текстуртэй, хүдрийн бусад эрдэс агуулаагүй байна.

1.4. Ордын нөөц

Улсын ашигт малтмалын нөөцийн сангийн комиссын 1991 оны 08-р сарын 09-ны өдрийн №5 тоот тогтоолоор ордын нөөцийг В+С1 зэргээр 1,565.8 мян.тн хайлуур жоншны хүдэр, хайлуур жоншны хүдэр дэх СаF2-ийн дундаж агуулга 38.85%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 608.3 мян.тн-оор хүлээн авсан байна. Цагаан Элгэний хайлуур жоншны орд нь “Төвшин” ХХК-ийн эзэмшлийн MV-011898 болон MV-009968 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайг дамнан оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй талбай дахь хайлуур жоншны нөөц, нөөцийн үлдэгдлийн тооцоог, 2018 онд мэргэшсэн геологич Д.Сүхбазар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай тус бүрээр, нөөцийн блок тус бүрээр салган тооцжээ. Тус нөөцийн үлдэгдлийн тооцоогоор MV-011898 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь ордын нөөц (С1) зэргээр 85.8 мян.тн хайлуур жоншны хүдэр, СаF2-ийн дундаж агуулга 32.57%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 27.9 мян.тн, (С1заб) зэргээр 25.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, СаF2-ийн дундаж агуулга 26.7%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 6.9 мян.тн, (С1+С1заб) зэргээр 111.6 мян.тн хайлуур жоншны хүдэр, СаF2-ийн дундаж агуулга 31.21%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 34.8 мян.тн байна. MV-009968 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь ордын нөөц (С1) зэргээр 229.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, СаF2-ийн дундаж агуулга 37.84%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 86.9 мян.тн, (С1заб) зэргээр 225.3 мян.тн хайлуур жоншны хүдэр, СаF2-ийн дундаж агуулга 21.83%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 49.2 мян.тн, (С1+С1заб) зэргээр 445.0 мян.тн хайлуур жоншны хүдэр, СаF2-ийн дундаж агуулга 29.92%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 136.1 мян.тн тус тус байна.

1.5. Ил уурхайн олборлолтын технологи

Ил уурхайгаар олборлох жоншны хүдрийн хэмжээ нийт 68.1 мян.тн, хөрс хуулалтын хэмжээ нийт 585.9 мян.м3, хөрс хуулалтын дундаж коэффициент 8.6 м3/тн байна. Ил уурхайн хүрээн дэх нийт жонш олборлолтын 94% нь бодитой В зэргийн нөөц, үлдсэн 6% нь боломжтой С зэргийн нөөц байна. Ордын уул-техникийн нөхцөл, ашиглах аргууд, хэтийн төлөв байдал зэргээс хамааруулж ил уурхайд авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системийг хэрэгжүүлэх нь хамгийн тохиромжтой байна. Ил уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй ажиллана. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана. Ил уурхайгаар олборлох нийт жоншны хүдрийн хэмжээ 68.1

мян.тн байна. Уурхайн төслийн хүчин чадал нь жилд 35.0 мян.тн жоншны хүдэр олборлох хүчин чадалтай байх бөгөөд төслөөр тогтоогдсон ил уурхайн ашиглалтын нийт хугацаа 2 жил байна.

Хүснэгт 1. Ил уурхайн хүрэн дэх жонш олборлолтын хэмжээ

д/д	Уурхай	Хөрс хуулалт, м ³	Хайлуур жоншны хүдэр, тн	СаF2-ийн дундаж агуулга, %
Хүдрийн биет-1	1-р ил уурхай	169,092	23,781	50.57
	2-р ил уурхай	156,749	18,300	45.72
	3-р ил уурхай	97,781	10,790	40.34
	4-р ил уурхай	72,714	7,897	32.69
Хүдрийн биет-2	5-р ил уурхай	27,192	2,693	34.85
	6-р ил уурхай	9,974	517	28.47
	7-р ил уурхай	52,462	4,161	60.26
Нийт		585,965	68,138	45.38

Хүснэгт 2. Хөрсний гадаад овоолгын төлөвлөлт

д/д	Уурхай	Хэмжих нэгж	Ашиглалтын жил		Нийт
			1-р жил	2-р жил	
Овоолгод хураагдах хөрсний хэмжээ					
Хүдрийн биет-1	1-р ил уурхай	м ³	169,092		169,092
	2-р ил уурхай	м ³	139,084	17,665	156,749
	3-р ил уурхай	м ³	-	97,781	97,781
	4-р ил уурхай	м ³	-	72,714	72,714
Хүдрийн биет-2	5-р ил уурхай	м ³	-	27,192	27,192
	6-р ил уурхай	м ³	-	9,974	9,974
	7-р ил уурхай	м ³	-	52,462	52,462
Нийт		м ³	308,176	277,789	423,623
Овоолго					
Нийт хөрс хуулалт		м ³	308,176	277,789	585,965
Сийрэгжилт		м ³	1.15	1.15	1.15
Овоолгод хураагдах чулуулгийн эзлэхүүн		м ³	354,403	319,457	673,860
Овоолгын талбай		га	4.87	0.09	4.96

1.6. Ил уурхайн процесс

Ил уурхайн ухаж ачих, тээвэрлэх, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой. Ил уурхайд дараах процессууд явагдана. Үүнд:

- Шимт хөрс хуулалт
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Ухаж ачих
- Тээвэрлэх
- Овоолох

1.7. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын тооцоо

Уг орд газрын үндсэн хүдэр агуулагч чулуулагт эхний метрт шавар, гүнрүүгээ карбонат, хлорит болон төмрийн гидроксидоор дүүргэгдсэн байна. Хөрсний чулуулгийн бат бэх $f=7.3$ байгаа нь өрөмдөж тэслэх зайлшгүй шаардлагатайг харуулж байгаа бөгөөд уг ажлын чанар технологийн бусад процесст хүндрэл үзүүлэхгүй байх шаардлагатай. Хөрсний чулуулгийг 100% өрөмдлөг-тэсэлгээгээр

сийрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хүдрийн биетийг өрөмдлөг-тэсэлгээгээр сийрэгжүүлэхгүй гэж үзсэн. Хөрсний доголыг өрөмдөхөд чулуулгаас хамааран HF100YA маркийн өрмийн машин ашиглана. “Цагаан Элгэн” хайлуур жоншны ордын жилд хуулах уулын цулын хэмжээ бага учир тэсэлгээг жилд 47 удаа хийнэ.

1.8. Далд уурхайн технологи

Орд нь ил уурхайн олборлолтоор нөөцийг бүрэн олборлож дуусаагүй тул нөөцөд үлдээх шаардлага гарна. Ил уурхайн ухшийг нөөцөд үлдээхэд чулуулгийн гулсалт, нуралтын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан авах шаардлагатай. Догол ба хажуугийн нуралт үүсэж болзошгүй хэсэг дэх тогтвортой биш хурдсыг цементлэх, чулуулагтай нь холбож бэхлэх, төмөр бетон шонгийн хийц, тулгуур хана ашиглах зэргээр бэхжүүлэх, тогтвортой болгох аргыг хэрэглэнэ. Уурхайн доголын сийрэг хурдастай налуу хэсгийг 30%-ийн мочевин-формальдегидын уусмал (давирхайн эзлэхүүний 5-6%-тай тэнцэх 5%-ийн уусмалыг нэмэх), латекс болон бусад бүтэц үүсгэгч бодисоор бэхжүүлэх, олон наст ургамал тариалах, бут сөөг суулгах зэрэг аргаар бэхжүүлнэ. Ухшийг нийтэд нь болон зарим нурамтгай хэсгийнх нь тогтворжилтыг сайжруулахын тулд хуулсан хурдасны зарим хэсгийг нураах, шүршмэл бетонон хольцыг хуурайгаар цацах ба нойтноор шүрших технологийг хэрэглэнэ. Ил уурхайн олборлолт явагдаж дууссаны дараа ил уурхайн гүнээс доош орших жоншны хүдрийн биетийг далд аргаар олборлохоор тооцлоо. Ашигт малтмалын Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн нийт 566.6 мян.тн хайлуур жоншны хүдрийн нөөц байна. Үүнээс ил уурхайгаар олборлох жоншны хүдрийн хэмжээ 68.1 мян.тн бөгөөд үлдэх нөөцийн хэмжээ 498.5 мян.тн байна. Ил уурхайн хүрээний гадна олборлолтод өртөхгүй хүдрийн хэмжээ 498.46 мян.тн ба үүнээс В зэргийн хүдрийн хэмжээ 251.3 мян.тн, С зэргийн хүдрийн хэмжээ 247.1 мян.тн тус тус байна. Ил уурхайн аргаар геологийн нөөцийн 12%-ийг олборлохоор байгаа бол ил уурхайн хүрээний гадна үлдэх нөөц нь геологийн нөөцийн 88% тус тус байна.

1.9. Далд уурхайн ашиглалтын нөөцийн тооцоо

Ил уурхайн олборлолт нь 16-36 м-ийн гүнтэй явагдах бөгөөд ил уурхайн ёроолын түвшнээс доош хамгаалалтын цул үлдээж, үлдэж байгаа нөөцөд тулгуурлан далд аргаар олборлох тооцоог хийлээ. Ил уурхайн олборлолт явагдсан ордод хамгаалалтын цулыг дараах аргачлалаар тооцно.

$$m_{х.ц} = 0.2 * H_y$$

Энд: H_y – Ил уурхайн гүн, м

Тооцоогоор хамгаалалтын цулын зузаан ил уурхайн гүнээс хамаарч 6 м байгаа бөгөөд уул геологийн нөхцөлөөс хамаарч газрын гадаргаас доош 6 м зузаан хамгаалалтын цулыг үлдээхээр тооцлоо. Хамгаалалтын цулаас доош орших хүдрийн биетийг, хүдрийн биетийн тогтцоос хамаарч 32-53 м өндөртэй, 45-80 м урттай далд уурхайн ашиглалтын блокуудад хувааж олборлохоор төлөвлөсөн. Далд уурхайн аргаар олборлох ашиглалтын нөөцийн хэмжээг биет болон далд уурхайн ашиглалтын блок тус бүрээр гарган дараах хүснэгтүүдэд үзүүлээ.

Хүснэгт 3. Далд уурхайн ашиглалтын блокууд, ашиглалтын нөөцийн тооцоо

Ашиглалтын блокийн дугаар	Түвшин, м	Нийт		
		Жоншны хүдэр, тн	Агуулга, % СаF2	Хайлуур жоншны хэмжээ, тн
Хүдрийн биет-1				
В-1	1108 м	4,132	19.15	791
В-2		7,555	27.48	2,076
В-3		12,925	52.24	6,753
В-4		9,740	43.55	4,241
В-5		8,293	26.27	2,179
В-6		10,486	24.90	2,611
В-7		12,664	38.21	4,839
В-8		1,860	27.32	508
В-9		4,802	19.83	952
В-10		12,207	32.41	3,956
В-11		17,261	33.76	5,828
В-12		6,131	19.56	1,199
В-13		2,847	23.74	676
В-14	1055 м	2,196	19.07	419
В-15		9,823	22.40	2,201
В-16		9,881	29.74	2,938
В-17		9,018	28.82	2,599
В-18		11,915	22.98	2,738
В-19		11,057	12.94	1,431
В-20		12,421	24.56	3,051
В-21		21,426	21.33	4,570
В-22		12,343	13.63	1,682
В-23	1005 м	4,772	22.01	1,050
В-24		9,775	16.67	1,629
В-25		11,942	17.85	2,131
В-26		12,055	17.81	2,147
В-27		9,938	15.11	1,501
В-28	960 м	2,996	18.10	542
В-29		1,259	13.80	174
В-30		3,590	13.62	489
В-31		6,184	15.03	929
В-32		6,688	19.32	1,292
В-33		7,659	19.32	1,480
		287,842	24.88	71,604
Хүдрийн биет-2				
В-34	1108 м	12,214	27.15	3,317
В-35	1108 м	9,463	31.30	2,961
В-36		12,680	36.45	4,622
В-37		5,767	31.88	1,838
В-38		11,276	40.24	4,538
В-39		7,727	36.15	2,793
В-40		6,611	31.58	2,088
В-41		5,403	19.23	1,039
В-42		3,116	25.35	790
В-43		8,849	33.94	3,003

В-44		14,089	31.52	4,441
В-45		4,311	34.34	1,481
В-46		7,105	38.43	2,731
В-47		796	28.45	226
В-48	1055 м	13,761	21.88	3,010
В-49		5,724	23.57	1,349
В-50		2,119	29.82	632
В-51		2,799	26.44	740
В-52		10,058	25.63	2,578
В-53		4,756	28.86	1,373
В-54		1,351	29.87	404
В-55		2,239	32.38	725
В-56		3,361	29.44	990
Нийт		155,578	30.64	47,670
Бүгд		443.421	26.90	119.273

Хүдрийн биет нь далд уурхайн ашиглалтын 56 блокт хуваагдсан бөгөөд далд уурхайн ашиглалтын нөөцийн хэмжээ нийт 443.40 мян.тн, CaF₂-ийн агуулга 26.90%, хайлуур жоншны нөөцийн хэмжээ 119.3 мян.тн байна. Тооцоогоор ил аргаар олборлох хүдрийн хэмжээ нийт хүдрийн нөөцийн 12%, далд аргаар олборлох хүдрийн хэмжээ нийт хүдрийн нөөцийн 88%, хамгаалалтын цулд үлдэх болон олборлолтод өртөхгүй хүдрийн хэмжээ нийт хүдрийн нөөцийн 10%-ийг тус тус эзэлж байна.

1.10. Ашиглалтын системийн сонголт

Хүдрийн биетүүдийн уналын өнцөг дунджаар 68-73 градус буюу эгц босоо уналтай, хүдрийн биетийн зузаан 0.6-2.84 м зузаантай, чулуулгийн бат бөхийн коэффициент 6.0-8.0 буюу бат бөх зэргийн чулуулагтай ордод хамаарна. Хүдрийн биетийн таазны зузааны үзүүлэлтээс хамаарч дунд зэргийн тогтвортой ордод орох тул хүдэр олборлолт, чулуулгийг нурааж ачихад нягтарших хүндрэл үзүүлэхгүй байна. Ордын геологийн тогтоц болон дээр дурдсан бусад үзүүлэлтүүдээс хамааран ордод хүдэр хоршоолох ашиглалтын системийг хэрэгжүүлэх нь хамгийн тохиромжтой байна.

Хүдрийг хоршоолон ашиглах ашиглалтын систем: Хүдрийг хоршоолон ашиглах ашиглалтын систем хэрэглэх үед блокийг бэлтгэхдээ хүдрийн биетийн дундуур штрекийг нэвтэрч, штрекээс блокийн захаар восстающийг хүдэр дундуур нэвтэрсний дараа бэлтгэл огтлолын бусад малталтуудыг ээлж дараалан нэвтэрнэ. Жигүүрийн восстающийг газрын гадаргууд нэвт гаргаж агааржуулалт болон бусад туслах материалыг авах боломж бүрдүүлэхээс гадна нөөц гарцаар тоноглоно.

Хэрэглэгдэх нөхцөл: Ил гадаргуутай таазын дор хүмүүс ажиллах тул тогтвортой байх шаардлагатай. Нураагдсан хүдрийг бага зайд чөлөөтэй буух боломжтой байлгахын тулд олборлох зузаан нь нимгэн судалд 1.0 м-ээс багагүй байх шаардлагатай. Хүдрийн биетийн уналын өнцөг 55-600-аас багагүй байх шаардлагатай.

Бэлтгэл ажил: Хамгаалах цул үлдээж ашиглах үед түүнд блокийн восстающийг байрлуулах үүднээс 2-4 м тутамд блокт орох холбоос малталт нэвтэрнэ. Хүний явуулыг блок тийш 30-400-ын налуу байршуулна.

Олборлох ажил: Энд огтлолын ажлыг хэвтээ үеэр 2 м-ийн өндөртэй үүсгэнэ. Өрөмдлөгийн өмнө таазанд үзлэг хийж аюулгүй байдлыг ханган хоршоолсон хүдрийн гадаргууг тэгшилнэ. Бэлтгэл ажил өрөмдлөгийн цагийн 20-30%-ийг эзэлнэ. Зарим тохиолдолд хоршоолсон хүдрийн хонхойсон гадаргуу дээр бэхэлгээ тавих ба бага зузаантай хэвтшийг олборлох үед тэлүүр дээр ажлын тавцанг байрлуулна. Хүдрийн ихэвчлэн 1.5-2.5 м өндөр хэвтээ үеэр олборлоно. Мөргөцгөөс хүдрийг тэслэн нураасны дараа 25-35 хувийг нь доош буулгана. Блокийн нөөцийг бүрэн нурааж дууссан дараа хүдрийг бүрэн буулгаж олборлоно. Хүдрийн биетийн тогтцоос хамаарч блокийн өндрийг 32-70 м, блокийн уртыг 45-80 м байхаар сонгосон. Блокт хүдэр нурааж олборлох ажил нь мөчлөг маягаар хийгдэнэ. Хажуугийн чулуулгийн тогтвор бага үед түүнийг штангин бэхэлгээ хэрэглэж болно. Хүдрийг хэсэгчлэн буулгаж байх үед түүнчлэн нийтэд нь буулгаж эхэлсний дараа мөргөцөг руу орохыг хориглоно. Ашиглалтын блокийн хэмжээ хүдрийн биет 1-ийг ашиглах уурхайд дунджаар 64*47 м хэмжээтэй, хүдрийн биет 2-ийг ашиглах далд уурхайд дунджаар 62*52 м тус тус хэмжээтэй байна. Ашиглалтын блокийн хэмжээг хүдрийн биет тус бүрийн ашиглалтын блокийн хэмжээг хэмжиж, блок тус бүрийн нөөцөд харьцуулан жигнэсэн дунджаар авч тооцсон буюу хүдрийн биет 1-ийг ашиглах далд уурхайн ашиглалтын блокийг бэлтгэх үед нийт бэлтгэл огтлолын малталтын хэмжээ 1139.6 м3 байна. Бэлтгэл огтлолын ажлаар блокийн нийт хүдрийн 11.33%-ийг олборлож, блокийн олборлолтоор 76.6%-ийг олборлохоор байна. Хүдрийн биет 2-ийг ашиглах далд уурхайн ашиглалтын блокийг бэлтгэх үед нийт бэлтгэл огтлолын малталтын хэмжээ 1142.4 м3 байна. Бэлтгэл огтлолын ажлаар блокийн нийт хүдрийн 11.8%-ийг олборлож, блокийн олборлолтоор 76.2%-ийг олборлохоор байна.

1.11. Далд уурхайн аргаар ашиглах үеийн жонш олборлолтын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Далд аргаар олборлох хүдрийн нийт хэмжээ 443.4 мян.тн ба ашиглалтын үеийн хүдрийн хаягдлын хэмжээ ордын хэмжээнд дунджаар 10.71%, бохирдлын хэмжээ ордын хэмжээнд дунджаар 11.02% байна. Олборлолтын явцад хүдрийн биет 1-ийг ашиглах далд уурхайд 10.89%-ийн хаягдал, хүдрийн биет 2-ийг ашиглах далд уурхайд 10.38%-ийн хаягдал тус тус үүсэхээр байна. Олборлолтын явцад хүдрийн биет 1-ийг ашиглах далд уурхайд 10.02%-ийн бохирдол, хүдрийн биет 2-ийг ашиглах далд уурхайд 12.86%-ийн бохирдол тус тус үүсэхээр байна. Далд уурхайн жонш олборлолтын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо нь хүдэр хоршоолох ашиглалтын систем хэрэглэх үеийн олборлолтын үеийн хаягдал бохирдлыг тооцсоноор үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ 439.54 мян.тн хүдэр болох юм.

Далд уурхайн ажлын горим: Далд уурхай нь хоногт 2 ээлжтэй, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.

Далд уурхайн хүчин чадал:

Далд уурхайн олборлолтын хүчин чадал нь дараах хүчин зүйлүүдээс ихээхэн шалтгаалдаг. Үүнд:

- Үндсэн болон бэлтгэл малталтуудын нэвтрэлтийн ажлын хурд, хэмжээ
- Олборлолтод бэлтгэх буюу нураалтын ажлын эзлэхүүн, хэмжээ, хурд
- Уул техникийн нөхцөлүүд болох уулын даралт, ус, хагарал, нуралт

Тооцоогоор ордын тогтоц нь жилд 38.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадлыг хангах боломжтой байна. Гэвч төсөл боловсруулах ажлын даалгаварт жилд 30.0 мян.тн хүдэр олборлохоор тусгасан тул бэлтгэл огтлолын ажил хангагдсанаар далд уурхайн жилийн хүчин чадлыг 30,000 тн/жил хүдэр олборлохоор байгаа юм.

Далд уурхайн ашиглалтын хугацаа: Ил уурхайн ашиглалт 2 жил явагдаж дуусах ба үргэлжлүүлэн далд уурхайн үндсэн малталт, бүтээн байгуулалтын ажлыг хийж, далд уурхайн олборлолтын ажлыг ашиглалтын 3-р жилд хийнэ. Төсөлд тооцогдсон хүчин чадлаар далд уурхайг ашиглах хугацаа 15 жил байх ба ордын хэмжээнд ашиглалтын хугацаа нийт 17 жил байна. Уурхайн нийт үндсэн болон бэлтгэл огтлол малталтуудын хэмжээ 190.8 мян.м3 эзлэхүүнтэй, 18.3 мян.м урттай байхаар төлөвлөгдөж байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль, газар зүйн онцлог

Далайн түвшнээс дээш 1250 м өргөгдсөн, даваа толгод, уул овоо, тал хөндий хосолсон газар нутагтай. Газар зүйн бүсчлэлийн хувьд сумын нутаг дэвсгэр нь бүхэлдээ говь хээрийн бүсэд багтдаг. Ургамлын бүрхүүлийн зонхилох хувийг хазаар өвс, монгол өвс эзэлдэг. Үүний зэрэгцээ төрөл бүрийн буурцагт ургамал элбэг бөгөөд хялгана, таана, хөмүүл, агь, гашуун, божмог, шар мод, шарилж, дэрс, суль, халгай, баглуур зэрэг ургамал өргөн тархсан. Сумын нутагт “Тогоон төмөр хааны балгас”, “Хэсэг байшинт”, “Сэнжит хад” зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд, “Хүн чулуу”, “Мэлхий чулуу” зэрэг түүхийн дурсгалууд цөөнгүй бий. “Хашаат худаг”-ийн нүүрс /нөөц нь 19,2 сая тн/, Зүүн цагаан дэлийн жонш /нөөц нь 3,2 сая тн/ зэрэг ашигт малтмалын нөөцтэй.

2.2. Зам тээвэр

Сумын хэмжээнд засмал болон сайжруулсан зам тавигдаагүй. Аймгийн төв болон багууд хоорондоо шороон замаар холбогддог. Цахилгаан хангамжийн хувьд төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон. Сумын төвд 1983 онд баригдсан 35,0 квт-ны хүчин чадал бүхий дэд станцтай.

2.3. Усан хангамж

Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худаг, 500 литрийн багтаамжтай 2 усан сан, цагт 32м3 хүчин чадалтай 1 насос станц, ус зөөлрүүлэх цэнгэгжүүлэх 1 төхөөрөмж, цэвэр усны 28,8 км урт шугам хоолойгоор гүний худгаас усан сангаар дамжуулан насосоор шахан шугам хоолойгоор түгээж байна. Төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд 200 өрх, 12 аж ахуйн нэгж байгууллага холбогдож, бусад айл өрхүүд ус түгээгүүрийн 2 цэгээс усаа авч ашигладаг.

2.4. Ариутгах татуурга

Сумын төвд ашиглалтаас гарсан 1 цэвэрлэх байгууламж, ашиглагдаж байгаа бохир усны 54 худаг, 4,6 км урт шугам хоолой байна. Төвлөрсөн бохир усны шугамд 200 өрх айл, 12 аж ахуй нэгж байгууллага холбогдсон.

2.5. Дулаан хангамж

Сумын төвд 3 зуухтай 1 дулааны станц ажиллаж байна. Энэ нь сард 887 кл/цаг дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 200 өрх, 12 аж ахуй нэгжид дулааныг түгээж байна.

2.6. Агаарын чанар

Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

2.7. Хөрсөн бүрхэвч

Төслийн хүрээнд төлөвлөж буй далд уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн уйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

2.8. Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн малталт, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

2.9. Гадаргын болон газрын доорх ус

Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч халихаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг бохирдуулах эрсдэлтэй байна.

2.10. Амьтны аймаг

Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах

чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

2.11. Ургамлан нөмрөг

Төслийн талбайд далд уурхай байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ.

2.12. Нийгэм эдийн засаг

Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

2.13. Төслийн хөрөнгө оруулалт

Цагаан Элгэний хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийг ажиллуулахын тулд ашиглалтын 17 жилийн хугацаанд нийт 28.5 тэрбум төгрөг шаардлагатай. Тус хөрөнгө оруулалтын 10.7 тэрбум нь анхны хөрөнгө оруулалт байх ба ашиглалтын хугацаанд 17.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр тооцооллоо. Ордын жилийн хүчин чадал 35.0 мян.тн байх ба баяжуулах үйлдвэр нь жилийн 250.0 мян.тн жонш баяжуулах хүчин чадалтайгаар байгуулагдах юм. Баяжуулах үйлдвэр нь өөрийн уурхайгаас олборлох хүдрээс гадна бусад уурхайгаас жонш худалдан авч баяжуулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр байгуулагдана. Уурхайн хөрөнгө оруулалтын хэмжээг хэсэг нэгжид хуваан харуулбал: Бэлтгэл ажил буюу уурхай эхлэхэд шаардлагатай бичиг баримтын бүрдэл болон хайгуул судалгааны ажлын зардалд 1.6 тэрбум төгрөг, ил уурхайд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 4.9 тэрбум төгрөг, далд уурхайн тоног төхөөрөмжид 8.0 тэрбум төгрөг, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжид 35.5 тэрбум төгрөг, уурхайн хотхоныг барьж байгуулах тохижуулах ажилд 3.8 тэрбум төгрөг, засварын цехийн тоног төхөөрөмжид 396.4 сая төгрөг, ордын цахилгаан хангамжид 2.3 тэрбум төгрөг, дулаан хангамжид 550 сая төгрөг тус тус зарцуулах ба уурхайн эргэлтийн хөрөнгийн хэмжээ 5.5 тэрбум төгрөг, үндсэн малталтын ажилд 114.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.

2.14. Төслийн борлуулалтын орлого

Төслийн хүрээнд ил уурхайн үйл ажиллагаа 2 жил явагдах ба 15 жилийн хугацаанд далд аргаар ашиглан нийт 511.6 мянган тонн хүдэр олборлон баяжуулж жоншны баяжмал /МГХЖ85/ 76.65 мянган тонныг үйлдвэрлэн борлуулах ба жоншны баяжмал /ХФ95А/ 1255.03 мянган тонныг тус тус үйлдвэрлэн борлуулна. Тус 2 төрлийн баяжмалыг БНХАУ-руу экспортлох ба жоншны баяжмал /МГХЖ85/-ыг 335.6 ам.доллар/тн буюу 1,141.2 мянган төгрөг, жоншны баяжмал /ХФ95А/-ыг 421.1 ам.доллар/тн буюу 1,431.9 мянган төгрөгөөр тооцож, жил бүрийн үнийн өсөлтийг харгалзан үзэж 0.1%-аар нэмэгдэхээр

төслийн үнэлгээг тооцлоо. Баяжуулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогод төслийн 17 жилийн хугацаанд нийт 1,891.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар байгаа ба үүний 87.6 тэрбум төгрөг нь /ХФ85/ жоншны баяжмалаас, 1,804.3 тэрбум төгрөг нь /МГХЖ95А/ жоншны баяжмалын борлуулалт байна.

2.15. Татвар төлбөр

Төсөлд татвар төлбөр, хураамжийг МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, тушаалын дагуу үндэслэн тооцсон. Төслийн хугацаанд нийт 526.4 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх бөгөөд үүний 515.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт, 10.8 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Хайлуур жоншны орд ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг БОНХАЖЯ-ны сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу Матрицын үнэлгээний аргыг ашиглан гүйцэтгэв. Тус матрицын үнэлгээний арга дээр тулгуурлан Олон улсын туршлагад өргөн хэрэглэгдэж буй нөлөөллийн үнэлгээний үр дагавар болон тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр ангилан хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Давтамжийн магадлал	Магадлалын тодорхойлолт	Тохиолдох давтамж	Бодисын нөлөөнд өртөх
A	МАШ ӨНДӨР	Төслийн үйл ажиллагааны хугацаанд олон давтагддаг тохиолдол	Өдөр тутам тохиолддог	Бодисын нөлөөнд олон давтамжтай өртдөг (өдөр бүр). Ажлын байрны өртөлтийн хязгаараас (АБӨХ) 10 дахин их
B	ӨНДӨР	Төслийн/үйл ажиллагааны хугацаанд олон давтагдах магадлалтай тохиолдол	Долоо хоногт 1-2 удаа тохиолддог	Бодисын нөлөөнд олон давтамжтай өртдөг (өдөр бүр) >Ажлын байрны өртөлтийн хязгаараас (АБӨХ) хэтэрсэн.
C	БОЛЗОШГҮЙ	Төслийн/үйл ажиллагааны хугацаанд тохиолдох магадлалтай	Сард 1-2 тохиолддог	Бодисын нөлөөнд олон давтамжтай өртдөг (өдөр бүр)>Ажлын байрны өртөлтийн хязгаарын (АБӨХ) 50% Бодисын нөлөөнд тогтмол өртдөггүй Ажлын байрны өртөлтийн хязгаар (АБӨХ).
D	БАГА	Төслийн/үйл ажиллагааны хугацаанд тохиолдох магадлал бага	Жилд 1-2 тохиолддог	Бодисын нөлөөнд олон давтамжтай өртдөг (өдөр бүр)>Ажлын байрны өртөлтийн хязгаарын (АБӨХ) 10% Бодисын нөлөөнд тогтмол өртдөггүй Ажлын өртөлтийн хязгаарын (АБӨХ) 50%

Е	ХОВОР	Төслийн/үйл ажиллагааны хугацаанд тохиолдох магадлал маш бага	5-10-аас жилд тохиолддог	Бодисын нөлөөнд олон давтамжтай өртдөг (өдөр бүр)>Ажлын байрны өртөлтийн хязгаарын (АБӨХ) 10%Бодисын нөлөөнд тогтмол өртдөггүй Ажлын байрны өртөлтийг хязгаарын (АБӨХ) 10%
---	-------	---	--------------------------------	---

Хүснэгт 5. Төслийн нийт нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа

д/д	1-Хөнгөн	2-Дунд зэрэг	3-Ноцтой	4-Онц ноцтой	5-Гамшгийн
	Шууд нөлөөлөл				
1	Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд хурдан хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой. (Ажлын нэг хоногт)	Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд богино хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой. (Долоо хоног)	Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд дунд хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой. (Нэг сар)	Нөлөөллийн цар хүрээ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүй бөгөөд удаан хугацааны нөхөн сэргээлт шаардагдана. Нөлөөлөл нь нөхөн сэргээгдэх боломжгүй хохирол үлдээнэ. (Олон жил)	Нөлөөллийн цар хүрээ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүй маш өргөн хүрээнд тархах ба урт хугацааны нөхөн сэргээлт шаардана. Нөлөөлөл нь нөхөн сэргээгдэх боломжгүй ноцтой хохирол үлдээнэ. (Олон жил)
	Шууд бус нөлөөл				
2	Байхгүй	Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд хурдан хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой. (Ажлын нэг хоногт)	Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд богино хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой. (Долоо хоног)	Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд дунд хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой. (Нэг сар)	Нөлөөллийн цар хүрээ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүй бөгөөд удаан хугацааны нөхөн сэргээлт шаардагдана. Нөлөөлөл нь нөхөн сэргээгдэх боломжгүй хохирол үлдээнэ. (Олон жил)

3.2. Төслийн нийт нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг агаар, ус, хөрс, амьтан, ургамал, түүх соёл гэсэн чиглэлүүдэд үнэлсэн байдаг бөгөөд гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт нь дараах үнэлгээтэй байна. Төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм-эдийн засаг, хүн амын амьдрах орчин, ажиллагсдын эрүүл мэндэд учруулах нөлөөлөл, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний магадлан жагсаах аргыг ашиглан тодорхойлсон болно.

3.3. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Жоншны ордыг ашиглах төслийн явцад шимт хөрс хуулах, далд уурхайн, овоолго үүсгэх зэрэг уулын бүхий л үйл ажиллагаагаар тодорхой талбайн хөрс хуулагдаж, үржил шимт хөрс болон ургамлан бүрхэвч зайлуулагдана. Мөн жонш олборлох машин механизм, тоног төхөөрөмж, тэдгээрт ашиглагдах шатах тослох материалын асгаралт зэргээс хөрсөн бүрхэвч бохирдох эрсдэлтэй. Жоншны ордыг ашиглах төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг нийт 6 үйл ажиллагаанаас 7 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 1 буюу 14.3% нь “дунд”, 5 буюу 71.4% нь “их” 1 буюу 14.3% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд их байхаар байна. Энэ нь төслийн зүгээс хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг сайтар авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ				Нийт
		Бага	Дунд	Их	Маш их	
1	Барилга байгууламж барьж байгуулах	-	-	1	-	1
2	Хөрс хуулалт	-	-	-	1	1
3	Хөрсний гадаад овоолго үүсгэх	-	-	1	-	1
4	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	-	1	-	-	1
		-	-	1	-	1
5	Засвар үйлчилгээ	-	-	1	-	1
6	Уурхайн гал тогоо, бусад үйлчилгээ	-	-	1	-	1
7	Нийт (тоогоор)	-	1	5	1	7
8	Нийт (%)	0	14.3%	71.4%	14.3%	100%

3.4. Газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ

Ордын талбайд 2021 онд гидрогеологийн судалгаа, газрын гүн дэх усны нөөцийн хэмжээ зэргийг тодорхойлохоор 100-150 м гүнтэй 4 ширхэг цооног өрөмдөн, шавхалт туршилтын ажил гүйцэтгэн, тоноглогсон. Гидрогеологийн цооногуудын туршилтын үр дүнгээр усны ундарга дунджаар 2.6 л/сек, усны тогтонги түвшин 27-56 м, уст үеийн байрлал 27-47 м тус тус байна. Гидрогеологийн судалгааны үр дүнгээр шүүрэлтийн коэффициент 0.01-0.05 м/хон буюу тооцоонд авах үр дүн дунджаар 0.052 м/хон байхаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Гидрогеологийн цооногийн шавхалт туршилтын үзүүлэлтээр уст үеийн байрлал дунджаар 40 м, ил уурхайн гүн 16-36 м бөгөөд уст үе нь ил уурхайн ёроолын түвшнээс доош байгаа тул ил уурхайд ус шүүрэн орж ирэхгүй гэж ТЭЗҮ-д үзсэн байна. Уурхайн нийт худгийн ундарга 9.1 л/сек байна. Энэхүү эх үүсвэрээс унд ахуй болон баяжуулах үйлдвэрийн хэрэглээ, зарим усны хэрэглээг хангахаар төлөвлөсөн байна. Уурхайд шүүрэн орж ирэх усны тооцоог, тухайн түвшинд олборлолт явагдах хугацаанд үндэслэн, жилд шүүрүүлэх, шавхан зайлуулах ус нь жилд 7532 м3/жил бөгөөд 22.2 м3/хоног байна. энэхүү ус нь далд уурхайн 2 дах жилээс ирлэнэ.

Жоншны ордыг ашиглах төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг нийт 7 үйл ажиллагааны 7 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 1 буюу 14% нь “бага”, 4 буюу 57% нь “дунд”, 2 буюу

28% нь “их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс усан орчинд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд дунд зэрэг байна.

Хүснэгт 7. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
		Бага	Дунд	Их	
1	Тоосжилт бууруулах үйл ажиллагаа	1	-	-	1
2	далд уурхайд орж ирэх усыг шүүрүүлэх	-	-	1	1
3	Шатахуун хадгалах, түгээх	-	1	-	1
4	Засвар үйлчилгээ	-	1	-	1
5	Уурхайн ухаш байгуулах, далан байгуулах	-	1	-	1
6	Тэжээгдэлийн мужаар дамжин газар доорх ус нь бохирдох	-	1	-	1
7	Хаягдлын сангийн нэвчилт	-	-	1	-
Нийт (тоогоор)		1	4	2	7
Нийт (%)		14%	57%	28%	100%

3.5. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

Хайлуур жоншны ордыг ашиглах төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг нийт 6 үйл ажиллагаанаас 7 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 3 буюу 42.8% нь “дунд”, 3 буюу 42.8% нь “их”, 1 буюу 14.3% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл нь их байхаар байна. Энэ нь төслийн зүгээс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг сайтар авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 8. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
		Бага	Дунд	Маш их	
1	Барилга байгууламж барьж байгуулах	1	-	-	1
2	Хөрс хуулалт	-	-	1	1
3	Хөрсний гадаад овоолго үүсгэх	-	1	-	1
4	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	1	-	-	1
		-	1	-	1
5	Засвар үйлчилгээ	-	1	-	1
6	Уурхайн гал тогоо, бусад үйлчилгээ	-	1	-	1
Нийт (тоогоор)		3	3	1	7
Нийт (%)		42.8%	42.8%	14.3%	100%

2.6. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Уурхайн суурингийн хөгжил, дэд бүтэц бараадсан хүн амын шилжин суурьшилт нэмэгдэхийн хирээр зэрлэг туруутан амьтдын хэвийн тогтвортой байршил алдагдахын сацуу хоолны газар болон ахуйн хэрэглээний зорилгоор хар сүүлтий, цагаан зээр, бор гөрөөс, зэрэг анг хууль бусаар агнах үйлдэл гарч болзошгүй. Жоншны ордыг ашиглах төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг нийт 5 үйл ажиллагаанаас 6 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 2 буюу 28.6% нь “бага”, 4 буюу 57.1% нь “дунд”, 1 буюу 14.3% нь “их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл нь дунд зэрэг байна.

Хүснэгт 9. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
		Бага	Дунд	Маш их	
1	Барилга байгууламж барьж байгуулах	1	-	-	1
2	Хөрс хуулалт	-	1	-	1
3		-	1	-	1
4	Хөрсний гадаад овоолго үүсгэх	-	1	-	1
5	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	1	-	-	1
6		-	1	-	1
7	Шатахуун хадгалах, түгээх	-	-	1	1
Нийт (тоогоор)		2	4	1	7
Нийт (%)		28.6%	57.1%	14.3%	100%

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Төвшин” ХХК-ийн цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан “Байгаль орчны төлөв байдлын тайлан”-г үндэслэн “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ” /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт/ зэрэг бичиг баримтуудыг удирдлага болгон түүнтэй холбогдсон харилцааг хуулийн хэм хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах байгаль орчинд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн боловсруулсан ба БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгав. Мөн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

Зорилго: Байгаль орчныг хамгаалах тухай хууль дүрэм журам хийгээд түүнтэй холбоотой харилцааг хууль эрхзүйн хэм хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаль орчны тэнцвэртэй бодлогыг бий болгон жонш тээвэрлэлт, хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл явцаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн арилгахад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

Зорилт: “Төвшин” ХХК-ийн цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин /агаар, ус, хөрс, ургамал, амьтан/ хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, орчны бохирдол, газрын доройтол, хөрсний элэгдэл эвдрэл цөлжилт үүсэхээс сэргийлэх, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн арилгах, “Тэрбум” мод хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нөхөн сэргээх, хог хаягдлыг зохистой менежментийг бий болгож үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, орчны хяналт шинжилгээг холбогдох стандартын дагуу тогтмол гүйцэтгүүлж мониторинг судалгаа хийх болон бусад арга хэмжээг дүрэм журам стандартын дагуу хэрэгжүүлэхээр “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-нд заагдсан дараах 11 төлөвлөлтийн дагуу 57 ажил хийгдэхээр нийт 87,901,000.00 /Наян долоон сая есөн зуун нэг мянга/ төгрөг төлөвлөв.

Хүснэгт 10. 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6,000,000.00
2	“Тэрбум мод” хөтөлбөр	25,000,000.00
	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	16,288,000.00
3	Нөхөн сэргээлт	Үйл ажиллагааны зардал
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	500,000.00
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,500,000.00
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,000,000.00
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9,120,000.00
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10,000,000.00
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7,493,000.00
10	Олон нийт оролцогч талуудад тайлагнах хуваарь	2,000,000.00
Нийт дүн		87,901,000.00

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахдаа үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөл, боломжийг бодитоор тооцоолон БОНБНҮ-ний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох дүрэм журам стандартуудыг мөрдөн хэрэгжилтийг хангаж ажиллах юм. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулахад Монгол улсад хүчин

төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжууд болон бусад хууль эрхзүйн баримт бичгүүд, төрийн байгууллагын тушаал шийдвэр, шаардлагыг биелүүлэхээс гадна үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад өдөр тутмын хэрэгцээнд мөрдөх тулгуур баримт бичиг, журмуудыг боловсруулан мөрдөж ажиллана.

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд баримтлах хуулийн жагсаалт

№	Хууль, эрх зүйн акт, стандартын бичиг баримтын нэр	Батлагдсан огноо
1	Үндсэн хууль	5/31/2023
2	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	8/30/2024
3	Зөвшөөрлийн тухай хууль	6/17/2022
4	Ашигт малтмалын тухай хууль	7/8/2006
5	Агаарын тухай хууль	5/17/2012
6	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	5/17/2012
7	Амьтны тухай хууль	5/17/2012
8	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	5/17/2012
9	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	5/17/2012
10	Байгаль хамгаалах тухай хууль	8/30/2024
11	Ойн тухай хууль	5/17/2012
12	Газрын хэвлийн тухай хууль	1/06/2023
13	Газрын тухай хууль	6/7/2002
14	Хог хаягдлын тухай хууль	5/12/2017
15	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	5/17/2012
16	Газрын төлбөрийн тухай хууль	4/24/1997
17	Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль	10/6/2011
18	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	5/25/2006
19	Галын аюулгүй байдлын тухай хууль	7/2/2015
20	Гамшгаас хамгаалах тухай хууль	2/2/2017
21	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль	5/22/2008
22	Байгалийн ургамлын тухай хууль	4/11/1995
23	Ургамал хамгааллын тухай хууль	11/15/2007
24	Зөрчлийн тухай хууль	5/11/2017
25	Эрүүгийн тухай хууль	12/3/2015
26	Цаг уур орчны шинжилгээний тухай хууль	11/13/1997
27	Хэмжилзүйн тухай хууль	5/9/2019
28	Геодези зураг зүйн тухай хууль	10/31/1997
29	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль	12/16/1999
30	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	11/15/1994
31	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	5/15/2014
32	Эрүүл ахуйн тухай хууль	2/4/2016
33	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	1/7/2005
34	Авлигын эсрэг хууль	6/7/2006

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

“Агаарын бохирдол” гэж хүрээлэн байгаа орчны агаарт шууд хаягдсан болон физик, химийн

урвалын дүнд шинээр үүсэж бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг хэлнэ. Төслийн үйл ажиллагааны явцад газар шорооны ажил, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт, хүдэр тээвэрлэлт, хүдэр бутлалт зэрэгт их хэмжээний тоосжилт үүсэх магадлалтай байдаг. Агаар мандалд эргэлдэж байгаа янз бүрийн хэлбэртэй хатуу, жижиг хэсгүүдийг тоос гэнэ. Тоосны хэмжээ нь 0,01-50 μm байна. Тоос нь гадаа задгай агаарт ч, өрөө тасалгаа, үйлдвэр дотор ч байх ба 1 μm –ээс жижиг хэмжээний тоосны хэсгүүд нь агаарын молекулын хөдөлгөөнд өртөн агаарт үргэлж хөдөлж эргэлдэж байдаг. Жонш олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны үед хөрс чулуулгийн гаралтай тоос тоосонцор ихээр үүсдэг тээврийн замуудаас үүсэх тоосыг хянах, техникүүдэд хурдны хязгаарлалт мөрдүүлэх нь хамгийн чухал юм.

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яааралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн талбай	ш	250,000.0	2.00	500,000.0	тухай бүр	MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025, “Агаарын тухай” хууль,
2		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засч сайжруулах		ш	75,000.0	20.00	1,500,000.0	өдөр бүр	
3		Уурхайн дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох		ш	-	1.00	үйл ажиллагааны зардал	жилд бүр	
4		Замын усалгааг тоосжилт ихтэй үеүдэд хийж байх		м3	-	-	үйл ажиллагааны зардал	5-10сар	
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал							2,000,000.0		

5.2. Гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төсөл нь Монгол улсын “Усны тухай хууль” түүнтэй холбоотой дүрэм, журам стандартуудын хэрэгжилтийг ханган ажиллана. Усны чанарын хяналт шинжилгээг хүнд металл, гол ион, биогени, ерөнхий үзүүлэлтүүдээр Монгол улсын Итгэмжлэгдсэн лабораторид хийлгэж ажиллана. Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрт хамгийн их усны хэрэглээ зарцуулагдах боловч ашигласан усны 90-95 хувийг дахин ашиглах ба энэ нь эргүүлэн ашигласан усны хэмжээгээр усны нөөцийг хэмнэх сайн талтай юм.

Хүснэгт 13. Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
5	Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Ус ашиглалттай холбоотой хууль эрхзүйн бичиг баримтуудыг бүрдүүлэх	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн талбай	ш	790,000.0	1	790,000.00	жилд бүр	“Усны тухай” хууль, Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 0899:1992 MNS ISO 5667-11 : 2000 Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж, Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам
6		Гүний худгийн ус хэрэглээг тоолууржуулах, тоолуурын бүрэн бүтэн байдал, лац хөндөгдөхгүй байхад тогтмол хяналт тавих		ш	450,000.0	2	900,000.0	сар бүр	
7		Сангуудын хяналтын цооногуудад үзлэг шалгалт хийж нэвчилт шүүрэл илэрч буй эсэхэд хяналт тавина.		ш	-	12	үйл ажиллагааны зардал	сар бүр	
Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал							1,690,000.0		

5.3. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Төслийн хүрээнд төлөвлөж буй далд уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн уйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

Хүснэгт 14. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
8	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн талбай	м³	-	-	үйл ажиллагааны зардал	тухай бүр	MNS 5916 : 2008, MNS 4628:2013 Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам”
9		Уурхайгаас өртөө хүрэх гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, сайжруулсан хайрган хучилттай болгох, цаашид арчилж тордох		км	-	12	үйл ажиллагааны зардал	Сар бүр	
10		Байгууллагын дотоод хэрэглээний ШТС-д MNS 4628:2013 стандартын дагуу дотоод хяналт хийж хөрсөнд асгаралт бохирдол үүсэхээс сэргийлнэ.		ш	500,000.00	2.00	1,000,000.00	хагас жил тутам	
11		Жонш тээврийн зам дагууд хуурай нойтон асгаралт үүссэн эсэхийг тогтмол шалгаж, Асгаралт саармагжуулах аюулгүйжүүлэх журам боловсруулж мөрдүүлнэ		ш	310,000.00			1 удаа	
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал							1,310,000.00		

5.4. Ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Ургамлын нөмрөгийн ашиглалт нь олон жилийн турш бэлчээрийн зориулалтаар ашиглаж ирсэн бөгөөд хадлан хадах зэргээр ашиглаж байсан мэдээ одоогоор бүртгэгдээгүй байна. Ургамлын нөмрөгийн бүрэлдэхүүний доройтол нь малын хөлийн талхагдал болон байгалийн хүчин зүйлийн зүй тогтлын нөлөөнд орсон байдлаар ажиглагдаж байна.

Хүснэгт 15. Ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
12	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Эрүүл ахуйн тухай хуулийн 13.1.6.энэ хуулийн 4.4.3-т заасан нийтийн эзэмшлийн зам, талбайг хог хаягдал, тогтоол ус, цас, мөсгүй байлгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шат, хашлага, хайсыг бүрэн бүтэн байлгах заалтыг хэрэгжүүлнэ.	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн талбай	ш	250,000.00	2.00	500,000.00	жилд 2 удаа	Эрүүл ахуйн тухай хууль, MNS 2418 : 2011, MNS 6138 : 2010 Мод тарих аргачлал
13		"Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны мэргэжлийн байгууллагаар говийн бүсийн зонхилох модлого ургамлын судалгааг хийлгэж 2026 онд мод тарих ажлын зохион байгуулах төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавина		ш	8,800,000.00	1.00	үйл ажиллагааны зардал	жилд 1 удаа	
14		Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан дараагийн жилүүдэд тарьж ургуулах модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлхэд хамтран ажиллана.		ш	10,000,000.00	1.00	үйл ажиллагааны зардал	жилд 1 удаа	
Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал							500,000.00		

5.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хуурай хээр, цөлийн хээр нь Монгол орны уулын тайга, уулын ойт хээрийн бүстэй харьцуулахад ургамлан бүрхэвчээр ядмаг, мөн гадаргын ус ховор билээ. Иймд амьтны аймгийн зүйлийн бүрдлээр дундаж хэмжээнд үнэлэгдэнэ. Тухайлбал, шувуудын зүйлийн бүрдлийн хувьд Монгол Дагуур, Дорнод Монголын тал хээр, Их Хянганы нуруу, Хангайн нуруу, Их нууруудын хотгор, Хөвсгөлийн уулс шувуудын зүйлийн бүрдлээр баялаг бол төслийн талбай хамаарагдах Хойд Говь, Дундад Халхын хээрийн тойрог нь ядмаг юм (S.Gombobaatar, 2011).

Хүснэгт 16. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
15	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн талбай	ш	0	0	үйл ажиллагааны зардал	тухай бүр	“Амьтны тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-ний тайлан, “Монгол улсын улаан ном”
16		Ажилчдад амьтан хамгаалах сургалт явуулах, ховор амьтад үйлдвэрийн бүсэд орж ирэх болон эрсдэл учирсан үед мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх		ш	0	1	үйл ажиллагааны зардал	жил бүр	
17		Жонш тээврийн зам дагуу "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4597:2014 MNS 1.22 "Мал тууж гарах газар" тэмдэг байршуулна.		ш	100,000.00	5.00	500,000.00	жилд 1 удаа	
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал							500,000.00		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хамгийн чухал асуудлын нэг бол уурхайн талбайг цаашид ямар зориулалтаар ашиглах, нөхөн сэргээлтийн чиглэл хамгаас чухал юм. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах чиглэл, цаашид ашиглах хэлбэрийг зөв тодорхойлсноор нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт Цагаан элгэний хайлуур жоншны ордыг 17 жилийн хугацаанд ашиглах бөгөөд ашиглаж дууссаны дараагаар уурхайн хаягдал, овоолго бусад эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйн чиглэлээр (бэлчээрийн чиглэлээр) сэргээлтийг хийнэ. Уурхайг ашиглаж дууссаны дараагаар бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх нь зүйтэй юм.

Хүснэгт 17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
18	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	Төслийн ил уурхай 2 жилийн турш үргэлжлэх тул нөхөн сэргээлт хийгдэхгүй. Уурхайн ашиглагдсан орон зай амсарыг тойруулан хүн, мал, техник орж осолдохоос сэргийлэн хашлага хаалт хийнэ.	га	7,290.80	2	үйл ажиллагааны зардал	тухай бүр	Хөрс цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS 6258-1 : 2011, MNS 6258-2 : 2011, MNS 1796 : 2011, MNS 6257 : 2011, MNS 6256 : 2011
19	Биологийн нөхөн сэргээлт	Төслийн талбайд мод тарих ажлыг зохион байгуулж эдэлбэр газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламж болгох зорилт дэвшүүлж ажиллана.	ш	7,000.0	100	700,000.0 (үйл ажиллагааны зардал)	9-11 сар	
Нөхөн сэргээлтийн арга хэмжээний нийт зардал								

7. "ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2021 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 58 тоот “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх тухай зарлиг, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн 350 дугаар тогтоолын хүрээнд "ТЭРБУМ МОД" ХӨТӨЛБӨР хэрэгжиж байна.

Хүснэгт 18. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд мод тарих байршлын координат

Иххэт сумын төвийн мод ойн зурвас байгуулах байршлын координат:	46°22'53.47"N	110° 5'45.03"E
	46°22'50.78"N	110° 5'47.74"E
	46°22'53.99"N	110° 5'55.69"E
	46°22'56.71"N	110° 5'45.03"E

Хүснэгт 19. "Тэрбум мод" хөтөлбөрийн төлөвлөгөө


№	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө		Хэмжих нэгж/	Тоо ширхэг	Нэгж үнэ/төг	Нийт үнэ/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
20	Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийн дагуу “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажилд санаачилгатай оролцож ойн зурвас байгуулах	Иххэт сумын төвд 2.0 га талбайг хашаалж хөрс бэлтгэл хийх, усалгааны систем угсарах	га	2.00	9,291,712.00	18,583,424.0 (үйл ажиллагааны зардал)	5-6сар	MNS 6258-1 : 2011, MNS 6258-2 : 2011, MNS 1796 : 2011, MNS 6257 : 2011, MNS 6256 : 2011, Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын норматив
21		Иххэт сумын төвд 2.0 га талбайд 10000 ширхэг шар хуайс, хайлаас, бургас, мөнгөлөг улиас, улиас зэрэг мод тарих.	ш	2.00	11,250,000.00	22,500,000.00	5-10 сар	
22		Иххэт сумын төвд 2.0 га талбайд тарвсан 10000 ширхэг модны усалгаа арчилгааг хийж ургуулах	хоног	2.00	4,350,000.00	8,700,000.00		
"Тэрбум мод" хөтөлбөрийн төлөвлөгөөний норматив зардал						31,200,000.00		

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 20. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд 2.0 га талбай хашаажуулах төлөвлөгөө

Ажлын нэр	Бараа материал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт	Нэгж үнэ/төг	Нийт үнэ/төг	Тайлбар
Иххэт сумын БОХУБ-аас зааж өгсөн байршилд 2.0га талбайг хашаажуулах	Бэлчээрийн тор	м	600.00	1.0м өндөртэй нүдний хэмжээ 7*7см	300,000.00	4,500,000.00	6.0 метр урттай хар трубааг 1.5 метрээр тайрч 2.0 га талбайд 3.0метр зайтайгаар шон болгож зоож бэлчээрийн тор бэхлэнэ.
		(нэг боодолдоо 40.0-45.0м)	(15 боодол)				
	Шон (Ф-4.0см, 6.0м урттай хар труба)	м	360.00	Ф-4.0см, 6.0м урттай хар труба	16,000.00	5,760,000.00	
		(1.5м өндөртэй)	60.0 ш труба (нийт 360.0м урт труба 240 ширхэг шон болно)				
	Чансаа	боодол	15	-	38,500.00	577,500.00	
	Пансаа	боодол	10	-	49,050.00	490,500.00	
	Галигуур	ш	10		13,200.00	132,000.00	
	Труба тастаж бэлтгэх гагнах	ш	240.0 ш	Ф-4.0см, 6.0м урттай хар труба	80,000.00	240,000.00	
		(1.5м өндөртэй)					
	Хашааны шон зоох (Техник түрээс)	ш	5 хоног	240.0 ш шон суулгах	900,000.00	4,500,000.00	
		(ковш)					
	Бэлчээрийн тор татаж чангалах	ш	5 хоног	нийт 600.0 м буюу 15 боодол тор	900,000.00	4,500,000.00	
		(ковш)					
	Мод тарих, хашаа барих жиллах хүч	10 ажилтан	15 хоног	-	70,000.00	10,500,000.00	
Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд 2.0 га талбай хашаажуулах зардал						31,200,000.00	

Зураг 5. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд мод тарих байршил



8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ. Тухайн төслөөс биологийн олон янз байдалд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх болон бууруулах арга хэмжээ авсны дараа үлдсэн сөрөг нөлөөллийг биологийн олон янз байдалд эерэг нөлөөтэй байхаар дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 21. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэг-жүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
23	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хөх өндөр гэх газар хууль бусаар олборлолт явуулсны улмаас эвдрэлд орсон 1 орчим га талбайд техникийн нөхөн сэргээлт,	Иххэт сумын нутаг дэвсгэрт	1 га буюу 10000м2	7,290.80	10,088,000.00	жилд 1 удаа	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5914:2008, Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
24	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд мод тарих, ургуулах, арчлах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх.	Иххэт сумын нутаг дэвсгэрт	2 га буюу 20000м2 талбайд 10000ш мод тарих	0	үйл ажиллагааны зардал	жилд 2 удаа	Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал						10,088,000.00		

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг Монгол улсын ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасны дагуу төлөвлөн хэрэгжүүлнэ. “Төвшин” ХХК-ийн “Цагаан Элгэний хайлуур жоншны ордын ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр” төслийн байгууламж нь хүн амыг суурьших бүсээс алс байрлах ба орчин тойронд нүүлгэн шилжүүлэх шаардлагатай айл өрх байхгүй.

Хүснэгт 22. Нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
25	Нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Иххэт сумын ХХҮГ-т бүртгэлтэй ажилгүй иргэдийг мод тарилт, усалгаа арчилгааны ажилд түр ажлын байраар хангах	Үйл ажиллагааны хүрээнд	-	10,000,000.00	Үйл ажиллагааны зардал	1-12 сард	Монгол улсын "Ашигт малтмалын тухай" хууль, Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 222 дугаар тогтоол, Иргэний хууль, Гамшгийн тухай хууль
26		Төслийн талбайн орчимд зуны улиралд нутаглаж буй малчин өрхүүдэд малаа хариулгатай байлгаж, төслийн талбайн нөлөөллийн бүсэд бэлчээрлүүлэхгүй байх талаар мэдэгдэл хүргэх, бүлгийн уулзалт хийх	Төслийн талбайн орчимд	5	200,000.00	Үйл ажиллагааны зардал	5-10 сард	
Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал						-		

10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 401 дүгээр зүйл. “Соёлын өвийг хамгаалах” 401.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 402, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ. 401.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. 402 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 402.1. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ, 402.1.2.Ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ” хэмээн заасан байдаг. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу судалгаа, шинжилгээ, малталтын дүн болон палеонтологи, археологийн олдворыг сумын захиргаанд тайлагнах юм. Түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд олдвор нь улсын өмч болдог. Археологи ба палеонтологийн үнэт дурсгалт зүйлс нь аль болох байгалийнхаа байсан газарт нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг.

Хүснэгт 23. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
27	Археологийн дурсгал	Төслийн талбайд археологи палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн мэргэжлийн байгууллагад мэдээлж ажиллана.	Төслийн талбайд	1	250,000.00	250,000.00	1-12 сард	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
28	Палеонтологийн дурсгал		Төслийн талбайд	1	250,000.00	250,000.00	1-12 сард	
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал						500,000.0		

11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайлуур жоншны орд ашиглах төсөл нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS 18000 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах нь зүйтэй.

“Осол” гэж тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, аваар осол, хүний алдаатай үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх системийн хэвийн бус ажиллагааг хэлэх бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд ирээдүйд үүсэж болзошгүй осол эрсдэлийг урьдчилсан таамаглан тодорхойлж байгаа болно.

“Байгалийн аюул” гэж хохирол, сүйрлийг өөртөө агуулж байж болзошгүй, биосферт явагддаг байгалийн үзэгдэл эсвэл үйл явцыг хэлэх бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд ирээдүйд үүсэж болзошгүй осол, байгалийн гамшгийг урьдчилан таамаглан тодорхойлж байгаа болно. Төслийн үйл ажиллагааны явцад хүний үйл ажиллагаа, техник технологи, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл болон байгалийн гамшиг, газар хөдлөл, үер, аянга цахилгаан хүчтэй шороон болон цасан шуурга зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр химийн бодисын осол эрсдэлээр үүсэж болзошгүй юм. Гамшгийн төрлүүдээс хамгийн түгээмэл нь үйлдвэрийн осол юм бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь санамсар, болгоомжгүй үйл ажиллагаанаас үүдэн гардаг. Энэ нь үйлдвэрийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах явцад ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, технологийн горим, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах хяналт суларснаас элдэв осол гарч, улмаар байгаль орчныг бохирдуулах, үйл ажиллагаа саатах, ажиллагсад болон үйлчлүүлэгчид хөдөлмөрийн чадвараа алдаж, тахир дутуу болох, цаашилбал амь насаа алдах эрсдэлтэй тул уг асуудлыг онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байдаг. Осол нь дараах хэлбэрээр гарах тул тэдгээрийн үнэлгээний суурь үзүүлэлт болгов. Үүнд:

- Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллах арга ажиллагааг мэдэхгүйгээс эрсдэлд өртөх;
- Цахилгааны холболтууд, трансформаторын төхөөрөмжийг мэргэжлийн бус хүмүүс дур мэдэн засаж, сэлбэхийг оролдсоноос осолд орох;
- Мэргэшиж дадлагажаагүй хүмүүсийг удирдлагын заавар, зөвшөөрөлгүйгээр ажиллуулснаас осол аваарт орох;
- Аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын дүрэм, горимыг зөрчсөнөөс осолд орох;
- Гал түймэр гарах;
- Зам, талбай, шат, тавцангийн эвдрэл, саад, халтиргааг анзаараагүйгээс болон өөрсдийн хайнга үйл ажиллагаанаас хальтагч унах, осол аваарт орох зэрэг болзошгүй ослоуд гарах магадлалтай юм.

Хүснэгт 24. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№		Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
29	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгааг нутаг дэвсгэрийнхээ байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч, онцгой байдлын газар, хэлтсээр хянуулж батлуулж байх;	Компанийн хэмжээнд	1	500,000.00	500,000.00	1-12 сард	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам, Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, MNS4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд.Хөдөлмөрийн эрүүл ахуй
30		Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалж хөдөлмөр хамгааллын хэрэгслээр тогтмол хангана. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм журам зааврыг чанд мөрдүүлж галын эрсдэлээс сэргийлэн аюул осолгүй ажиллуулна.	Компанийн хэмжээнд	тогтмол	Үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5%	үйл ажиллагааны зардал	1-12 сард	
31		Эрүүл мэндийн үзлэгт ажилчдаа тогтмол хамруулах;	Компанийн хэмжээнд	тогтмол		үйл ажиллагааны зардал	1-12 сард	

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

32		Химийн бодистой харьцах, галын аюулгүй байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтад ажилчдыг хамруулах	Компанийн хэмжээнд	50	100,000.00	5,000,000.00	1-12 сард	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам, Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, MNS4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд.Хөдөлмөрийн эрүүл ахуй
33	Байгалийн гамшигт үзэгдэлийн осол эрсдэлийн менежмент	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэлтэй байх	Компанийн хэмжээнд	365	25,000.00	үйл ажиллагааны зардал	1-12 сард	
34	Химийн бодисын осол эрсдэлийн менежмент	Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайланг БОАЖ-н сайдын 2018 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу жил бүрийн 11 сарын 20-ны дотор гарган баталгаажуулж аймгийн БОГ-т ирүүлэх. Аюултай хог хаягдлын ангилан ялгаж тус бүрээр нь бүтгэлжүүлэн аюулгүй байдлыг хангаж хуулийн хугацаанд хадгалах	Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн талбай	1	4,000,000.00	4,000,000.00	1-12 сард	
35		Химийн бодисын тусгай зөвшөөрөл, химийн бодисын орлого зарлагын бүртгэл хөтлөх, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах	Компанийн хэмжээнд	12	166,666.67	2,000,000.00	1-12 сард	
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал						11,500,000.00		

12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэрийг хязгаарлах, хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр цуглуулах, хог хаягдлыг богино хугацаанд зайлуулан, орчныг цэвэрлэх зэрэг арга хэмжээнд тулгуурлана. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлыг цуглуулах, хадгалах, зөөж тээвэрлэх, дахин ашиглах гэсэн аргуудыг сонгон ашиглаж Монгол улсын “Хог хаягдлын тухай хууль”-ийг хэрэгжүүлэн ажиллана. Ахуйн хог хаягдлыг зайлуулах арга зам: “Төвшин” ХХК нь ахуйн хатуу хог хаягдал зайлуулах асуудлыг "Хог хаягдлын тухай" хуульд заасны дагуу орон нутгийн ТҮК тай байгуулах гэрээний дагуу шийдвэрлэнэ. Зөөвөрлөн зайлуулах хуурай хог хаягдлыг тагтай, ёроол нь битүү, хагарч цоороогүй нийлэг эсвэл металл сав тавьж хогоо хийж байнга таглаж байх, хогийг ангилан (төмөр, шил болон нийлэг сав суулга, цаас, яс гэх мэт) ялгаж хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгжид нийлүүлэх, борлуулах зэргээр хаягдал хогийг багасгах, хоггүй технологи нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллана.

Төслийн хүрээнд үүсэх ахуйн хог хаягдал: 20 01 01-Цаас, картон, 20 01 02-Шил, 20 01 03-Био задралд ордог хоол, хүнсний бүтээгдэхүүний хаягдал (гал тогоо, гуанз, ресторан кафе гэх мэт), 20 01 04-Хувцас, 20 01 05-Нэхмэл эдлэл, 20 01 13-Хүнсний өөх тос, 20 03 05 Бохир ус цэвэрлэгээнээс гарсан хаягдал, 20 01 27-Хуванцар, 20 01 28-Металл, 16 01 01-Ашиглалтаас гарсан дугуй, 16 01 03-Шингэн болон хортой бодис агуулаагүй ашиглалтаас гарсан машин.

Төслийн хүрээнд үүсэх аюултай хог хаягдал: 13 02 05*Хөдөлгүүр, хурдны хайрцгийн болон тосолгооны бусад тос(А), 13 0 501* Түлшний тос, дизель(А), 13 0 502* Бензин(А), 16 01 02* Ашиглалтаас гарсан автомашин(А), 16 01 04* Тосны шүүр(А), 16 01 05* Мөнгөн ус агуулсан эд анги(Х), 16 01 06*Полихлорт бифенил (PCBs)агуулсан эд анги(Х), 16 01 07*Тэсрэмтгий эд анги(хамгаалалтын дэр г.м)(А), 16 01 08*Асбест бүхий тоормосны жийргэвч (накладка)(А), 16 01 10*Тоормосны шингэн(А), 16 01 11*Аюултай нэгдэл агуулсан антифризийн шингэн (Х), 16 06 01*Хар тугалгатай батарей, аккумулятор(А), 16 06 02* Никель - Кадмийн батарей(А), 16 06 03* Мөнгөн ус агуулсан батарей(А), 16 06 06*Батарей, аккумулятораас ялгаж авсан электролитийн уусмал(А), 20 01 29* Зуухны доод үнс, яндангийн хөө(Х)

Төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллахад 218 хүн ажиллах ба 1 хүнээс хоногт 0.3кг энгийн хог хаягдал үүсэж байдаг. /Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар хүн хоногт 0.290 кг ахуйн хог хаягдал ялгаруулж хаядаг гэсэн тооцоо байдаг./ Ингээд үзэхэд сард 2.0 тн, жилд 24.00тн ахуйн хог хаягдал гарах тооцооллыг хийв. Үүн дээр бараа материалын хайрцаг сав, уут, нийтийн хоол үйлдвэрлэлээс гарах хаягдал хоол хүнс, хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэл хальс, муудсан ногоо, галлагаанаас гарах үнс гэх мэт ахуйн гаралтай энгийн хог хаягдлууд нэмэгдэж үүсэх юм. Ажилчдын амрах сууц, хоолны газар, амралтын талбай, угаалга, бие засах газарт хогны уут, жижиг хогийн савнуудыг байршуулан хог хаягдлыг төрөлжүүлэн цуглуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, үүссэн хог хаягдлыг тухай бүр хогийн түр цэгт төвлөрүүлэн хэрэгжилтэд нь байнга хяналт тавина.

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 25. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэр	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэг-жүүлэх хугацаа	Баримтлах хууль журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
36	Үйлдвэрийн хог хаягдлын менежмент	"Хог хаягдал дарж устгах гэрээ"-г Иххэт сумын ЗДТГ-тай байгуулан устгуулсан хог хаягдлын бүртгэл хөтөлж баталгаажуулан төлбөрийг төлж барагдуулна.	Төслийн бүсэд	м³	220,000.00	12.00	2,640,000.00	1-12 сард	Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралт Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт
37		Хог хаягдлын менежментийн системийг сайжруулж ажилчдад тоштмол сургалт сурталчилгаа, мэдлэг мэдээлэл олгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж ажиллана.	Төслийн бүсэд	ш	105,000.00	4	420,000.00	1-12 сард	
38		Хог хаягдлыг ангилах, хогийн савнуудыг ангилан ялгалт хийх боломжтойгоор байршуулна.	Төслийн бүсэд	ш	270,000.00	9	2,430,000.00	1-12 сард	
39	Ахуйн хог хаягдлын менежмент	Хаягдлын сангаас нэвчилт бохирдлыг шалгах, Хаягдлын даланд хяналт шалгалтын 14 хоног тутамд хийх	Төслийн бүсэд	ш	Үйл ажиллагааны зардал	24.00	Үйл ажиллагааны зардал	1-12 сард	

“Төвшин” ХХК-ийн Цагаан элзэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

40	Аюултай хог хаягдлын менежмент	Ажилчдын ариун цэврийн өрөө, жорлонг Тамир эм бэлтмэлийн ариутгалын бодисоор ариутгах	Төслийн бүсэд	ш	5,000.00	126.00	630,000.00	1-12 сард	
41	Аюултай хог хаягдлын менежмент	Химийн бодис, шатах тослох материалын гаралтай аюултай хог хаягдлыг холбогдох дүрэм журам стандартын дагуу стандарт шаардлага хангасан агуулахад бүртгэлжүүлэн хадгалж хуулийн хугацаанд мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгч устгуулна. Үүнд: Бүх төрлийн зай хураагуур, аккумулятор, химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол, бүх төрлийн машин механизмын тос, тосолгооний бүтээгдэхүүн	Төслийн бүсэд	ш	3,000,000.00	1.00	3,000,000.00	1-12 сард	хаягдлын тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралт Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал							9,120,000.00		

13. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйл “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, 9.7 дахь заалт “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн заасан байна. Үүний дагуу бид БОНБНҮ-ний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Хүснэгт 26. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Тайлбар	Баримтлах хууль журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1. Агаарын чанарын хяналт шинжилгээ								
42	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А)	Ажилчдын кемп орчим	5, 10 сар	2	139,000.00	278,000.00	БОШЛ, БОХЗТЛ	MNS 4585:2016, Монгол улсын “Агаарын тухай” хууль
		Баяжуулах үйлдвэр орчим			139,000.00	278,000.00		
		Уурхай орчим			139,000.00	278,000.00		
		Овоолго орчим			139,000.00	278,000.00		
		Хаягдлын сан			139,000.00	278,000.00		
Агаарын чанарын хяналт шинжилгээний нийт мөнгөн дүн						1,390,000.00		
2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ								
43	Механик бүрэлдэхүүн, Агрохими (гр/кг)	Ажилчдын кемп орчим	5, 10 сар	2	95,000.00	190,000.00	БОШЛ, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Нарт шүүн консалтинг ХХК	Хөрс цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS5850:2019 MNS 3297:2019
		Баяжуулах үйлдвэр орчим	5, 10 сар	2	95,000.00	190,000.00		
		Уурхай орчим	5, 10 сар	2	95,000.00	190,000.00		
		Овоолго орчим	5, 10 сар	2	95,000.00	190,000.00		
		Хаягдлын сан	5, 10 сар	2	95,000.00	190,000.00		
		Химийн бодисын агуулах	5, 10 сар	2	95,000.00	190,000.00		
		Хаягдлын сангийн талбай	5, 10 сар	2	95,000.00	190,000.00		

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

44	Хөрсний бохирлол, Хүнд металлын шинжилгээ (гр/кг)	Ажилчдын кемп орчим	5, 10 сар	2	87,800.00	175,600.00	Хан Лаб ХХК	Хөрс цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS5850:2019 MNS 3297:2019
		Баяжуулах үйлдвэр орчим	5, 10 сар	2	87,800.00	175,600.00		
		Уурхай орчим	5, 10 сар	2	87,800.00	175,600.00		
		Овоолго орчим	5, 10 сар	2	87,800.00	175,600.00		
		Хаягдлын сан	5, 10 сар	2	87,800.00	175,600.00		
		Химийн бодисын агуулах	5, 10 сар	2	87,800.00	175,600.00		
		Хаягдлын сангийн талбай	5, 10 сар	2	87,800.00	175,600.00		
Хөрсний чанарын хяналт шинжилгээний нийт мөнгөн дүн						2,559,200.00		
3. Усны чанарын хяналт шинжилгээ								
45	MNS 0900:2018 Ерөнхий үзүүлэлт, химийн үзүүлэлт, хүнд металл	Уурхайн усан хангамжийн худаг	5,10 сар	4	315,600.00	1,262,400.00	Хан Лаб ХХК	MNS 0900:2018
46	pH, Ж.б, XXX, BXX5, HN4, NO2, NO3, N нийт, Р эрд	Хаягдал бохир ус-ахуйн (мг/л) /цэвэрлэх байгууламжийн оролт, гаралт/	1, 4, 6, 8 сар	4	164,000.00	656,000.00	БОШЛ	MNS 4943 : 2015
Усны чанарын хяналт шинжилгээний нийт мөнгөн дүн						1,918,400.00		
47	Ургамлан нөмрөгийн судалгаа	Мониторингийн цэгүүдэд ургамлын биохимийн шинжилгээ	5,10 сар	4	406,350.00	1,625,400.00	Нарт шүүн консалтинг ХХК	
48	Амьтны аймгийн судалгаа	Амьтны мониторингийн 3 цэгт	10 сар	3	-	үйл ажиллагааы зардал	Байгаль орчны мэргэжилтэн	
Орчны хяналт шинжилгээний нийт мөнгөн дүн						7,493,000.00		

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний биелэлтийн явцыг удирдлагын хэмжээнд танилцуулан, сайжруулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай зэрэгцээ байгаль орчны төрийн болон орон нутгийн хяналтын байгууллагатай хамтран ажиллана. Мөн “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль болон тайланд тусгагдсан зөвлөгөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайлагнах үүрэг хүлээхээс гадна боловсон хүчний тогтвортой байдлыг бий болгож, чадавхжуулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна

Хүснэгт 27. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцан зохион байгуулах албан тушаалтан
			2026он			
			3 сар	6 сар	9 сар	
	1	2	3	4	5	6
49	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101-1-д заасны дагуу Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж зөвлөмжийн биелэлтийн тайланг ирүүлэх	18,000,000.0 (үйл ажиллагааны зардал)	8-9 сард			Гүйцэтгэх захирал, Төслийн менежер, Ерөнхий инженер, Байгаль орчны мэргэжилтэн
50	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон Дорноговь аймгийн БОГ-т хүргэн өгч байх	500,000.00	1-6 сард			
51	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	1,000,000.00	1-6 сард			
52	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төлөвлөж өгсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллах	43,950,500.00	1-6 сард			
53	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг хуулиар тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	7,500,000.00	1-9 сард			
54	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	1,000,000.00	1-12 сард			
Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний зардал		10,000,000.00				

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай компани нь Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд болон төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж тайлагнах”, 18 дугаар зүйлийн 18.4-д “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч хэлэлцүүлэг зохион байгуулна”, нарийвчилсан үнэлгээний тайлан шинээр хийгдэх болон тодотгол хийгдсэн тохиолдолд тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна. тусгасныг хэрэгжүүлэн ажиллах юм.

Хүснэгт 28. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал /төгрөг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан, ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
55	Дорноговь аймгийн БО-ны салбар байгууллагууд /төрийн/-д БОУАӨЯ-нд тайлагнах	Дорноговь аймгийн БО-ны салбар байгууллагууд /төрийн/-д БОМТ-ний гүйцэтгэлийг тайлагнаж дүгнүүлэх, БОМТ-ний тайланг мэдээллийн санд байршуулж БОУАӨЯ-аар батлуулах	2026 оны БОМТ-ний биелэлт дүгнүүлэх	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэх захирал, ХАБЭАБОХ	Дорноговь аймгийн Байгаль орчны газар
56	Дорноговь аймгийн байгаль орчны газар	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	2026 оны БОМТ-ний биелэлт дүгнүүлэх	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэх захирал, Байгаль орчны удирдлагын алба	Шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр хурал зөвлөгөөн зохион байгуулах,

“Төвшин” ХХК-ийн Цагаан элгэн хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

57	Иххэт сумын Засаг даргын тамгын газарт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	2026 оны БОМТ-ний биелэлт дүгнүүлэх	Жилд 1 удаа	2,000,000.00	Гүйцэтгэх захирал, Байгаль орчны удирдлагын алба	тайланг хэвлэмэл байдлаар хүргүүлж болно.
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал					2,000,000.00		